

## Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны

2016 оны 03 сарын мэдээ

2016 оны 03 дугаар сарын 30

### Байгалийн нөөц хамгаалал, ашиглалт

Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Сайдын 2015 оны 12-р сарын 4-ны өдрийн “2016 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” А/415 дугаар тушаалыг үндэслэн Орхоны хөндийн БЦГ-ын ой санд ойн цэвэрлэгээ явуулах аж ахуй нэгжүүдийн дунд тендер зарлан сонгон шалгаруулалт явууллаа.

Тендэрт оролцохоор ойн мэргэжлийн эрх бүхий 6 аж ахуй нэгж хүсэлтээ ирүүлсэнээс Өвт хайрхан ХХК, Хархорин дахь ШШГГазар, Сүүн далай ХХК, Өгөөмөр шунхлай ХХК-ууд шалгарч ТХГН-ын ойд цэвэрлэгээ хийх эрх авсан.

Хамгаалалтын захиргааны албан хаагчид Батөлзий суман дахь Сум дундын ойн ангитай хамтран ойн цэвэрлэгээ хийх талбайг Бат-Өлзий сумын Могойт, Хамрын аманд сонгон тусгаарлаж шалгарсан ААН-үүдэд талбайг хуваарилан өгч ойн цэвэрлэгээний ажлыг гүйцэтгүүлж байна.



ТХГН-т хийгдэж байгаа ой цэвэрлэгээний арга хэмжээнд хамгаалалтын захиргаанаас 8 байгаль хамгаалагч, мэргэжилтэн оролцож хяналт тавьж ажиллаж байна.

Бат-Өлзий сумын Төвхөн, Тонгоргын даваа, Хан баян уул, Могойтын эх, Хархорин сумын Баянзүрх орчимд зэрлэг амьтанд зориулсан хужир, хивэг тавих ажлыг байгаль хамгаалагч нартай хамтран зохион байгууллаа.

Хамгаалалтын захиргааны Мэргэжилтэн, байгаль хамгаалагч, Эрдэнэзуу хийдийн лам нар, Этүгэн Улаач ТББ-тай хамтран Өвөрхангай аймгийн Хархорин сумын ТАХИЛАГТ ХАНГАЙ ХАЙРХАНЫ ойр орчмын хог хаягдал, хадаг, самбааг цэвэрлэж овоог сэргээлээ.



ХБНГУ, Монгол улсын Засгийн газрын санхүүжилтээр ТХГНутагуудад хэрэгжихээр зарлагдсан БОЯБХУАӨДЗТөслийн 1-р шатны шалгаруулалтанд хамгаалалтын захиргаа шалгарч, 2-р шатны шалгаруулалт, төслийн танилцуулгын сургалт семинарт оролцлоо.

Тус төслийн дэлгэрэнгүй төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд хамгаалалтын захиргаатай хамтран оролцох гол түншлэгчид Улаанбаатар хотноо 3 өдрийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Уулзалтаар түншлэгч байгууллагуудын оролцоо, хийх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хувь хэмжээг тохирон баталгаажууллаа.

### **Мэдээлэл, сургалт, сурталчилгаа**

Орхоны хөндийг Улсын тусгай хамгаалалтанд авсаны 20-н жил Хамгаалалтын захиргаа үүссэн байгуулагдсаны 10 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгууллаа. Өдөрлөгөөр сумын иргэдэд мэдээлэл сурталчилгааны тараах материалаар үзүүлэн бэлдэж, 4-р баг, төвийн багийн хуралд 2 удаагийн мэдээлэл танилцуулга хийж, иргэдийн асуултанд хариуллаа.



ТХГН-ын ойн цэвэрлэгээний кино үзүүлэн иргэдийн дунд Орхоны хөндийн талаарх танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн зохион шалгарсан нэг хүн мөн байгаль хамгаалах “Харуул магнай” нөхөрлөлийг шилдэг нөхөрлөлөөр шалгаруулан шагнаж урамшууллаа.



Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын салбарын 2016 оны удирдах ажилтны зөвлөгөөн 2016 оны 03-р сарын 17-нд Өвөрхангай аймагт цахим хэлбэрээр явагдаж Хамгаалалтын захиргааны дарга Г.Эрдэнэбилэг оролцлоо.

Хархорин сумын орчны бүсийн зөвлөл хуралдлаа. Хурлаар ОБЗ-ийн 2016 онд хийх ажлын төлөвлөгөө, ОБ-ийн сангийн зарцуулалтын талаар хэлэлцэн баталлаа.



Өвөрхангай аймгийн Мэргэжилийн хяналтын газраас жил бүр зохион байгуулдаг улсын байцаагч нарын сургалтанд Хамгаалалтын захиргааны Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэчимэг оролцлоо.



Орхоны хөндийн БЦГазар нутагт 2010-2015 онд хэрэгжсэн НҮБ-ын ТХГНСБэхжүүлэх нь төслийн хаалтын семинар Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж хамгаалалтын захиргаа, орон нутгийн захиргаа, бүлэг нөхөрлөлийн төлөөллүүд оролцлоо.



Зөвлөгөөний үеэр төслийн үр дүнд бий болсон чадавхийг бусад захиргаадад танилцуулан, хөрөнгө оруулалтыг орон нутагт хүлээлгэн өглөө.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн

Ч.Суурьтогтох.